



**НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар A/03

Улаанбаатар хот

□ Чанарын менежментийн тогтолцооны
MNS ISO 9000:2016 стандарт
нэвтрүүлэхэд ашиглах журам
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны А/11 дүгээр тушаал, байгууллагын даргын А/11 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. MNS ISO 9001:2016 стандартын зарим шаардлагыг хангах зорилгоор дотоод аудитын журмыг нэгдүгээр, удирдлагын дүн шинжилгээний журмыг хоёрдугаар, үл тохирол ба залруулах арга хэмжээний журмыг гуравдугаар, чанарын менежментийн тогтолцооны журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Дотоод аудитын журам, удирдлагын дүн шинжилгээний журам, үл тохирол ба залруулах арга хэмжээний журам, чанарын менежментийн тогтолцооны журмыг нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, хэрэгжүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Цогзолмаа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ

